



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/НЧ/

Ховд

Шагнаж хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын гавъяат тамирчин, жү-до бөхийн олимпын аваргын хүрэл медальт Ховд аймгийн олимпын анхны медальт тамирчин, самбо бөхийн дэлхийн аварга, улсын начин Ховд аймгийн Дарви сумын уугуул иргэн Равдангийн Даваадалайгийн биеийн тамир, спортын салбарт гаргасан амжилт, аймаг, орон нутагт үндэсний болон жү-до бөхийг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, хөдөлмөр бүтээлийн үр дүнг өндрөөр үнэлж, жү-до бөхийн 2019 оны улсын аварга шалгаруулах тэмцээнийг түүний нэрэмжит болгож Ховд аймагт зохион байгуулсаныг тэмдэглэн 18.5 сая төгрөг /арван найман сая таван зуун мянган/-ийн үнэ бүхий суудлын автомашинаар шагнаж урамшуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 18.5 сая төгрөгийг сая төгрөгийг аймгийн хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.11-д баталсан хөтөлбөрийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ